


Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны
10 дүгээр сарын 07 ны өдрийн 27 дугаар
тогтоолын нэгдүгээр хавсралт



ШҮҮГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд анх удаа томилогдсон шүүгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Хоёр. Шүүгчийн тангараг

2.1. Монгол Улсын шүүгч /цаашид “Шүүгч” гэх/ томилогдсон өдрөөсөө хойш ажлын гурван өдрийн дотор “Шүүгч би шүүх эрх мэдлийн ариун журамт үүрэг, Монгол Улсын Үндсэн хуульд байгуулал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж, хэрэг, маргааныг хэнээс ч хараат бус, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйг чанд сахиж явахаа ард түмэндээ батлан тангараглая. Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал шүүгчийн албан тушаалаас нэн даруй огцорч, хуульд заасан хариуцлага хүлээнэ.” гэж Монгол Улсын Үндсэн хууль болон Төрийн сүлдэнд тангараг өргөнө.

2.2. Шүүгчийн бүрэн эрх нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан журмын дагуу томилогдон, тангараг өргөснөөр эхэлнэ.

2.3. Шүүгчийн албан тушаалаас хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөний дараа шүүгчээр дахин томилогдсон тохиолдолд шүүгчийн тангараг шинээр өргөнө.

Гурав. Шүүгч тангараг өргөх ёслолын ажиллагаа

3.1. Тухайн шүүхийн тамгын газар шүүгчийн тангараг өргөх газар, хугацаа /өдөр, цаг/-г тухайн шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн тогтоож, тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийг хангаж, зохион байгуулна.

3.2. Шүүгчийн тангараг өргөх байрыг ёслол төгөлдөр тусгайлан бэлтгэж, Монгол Улсын төрийн сүлд, төрийн далбааг хүндэтгэлтэйгээр байрлуулна.

3.3. Тангараг өргөх шүүгч тогтоосон цагт, тусгайлан бэлтгэсэн байранд хүндэтгэлтэйгээр орж, Монгол Улсын төрийн сүлд рүү харан цэх зогсоно. Шүүгч тангараг өргөх үед оролцогчид босож хүндэтгэнэ.

3.4. Шүүгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг тухайн шүүхийн тамгын газрын дарга удирдах ба тангараг өргөх ёслолын ажиллагааг нээж, оролцогчдыг

танилцуулан, шүүгчийн албан тушаалд томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг сонордуулж, ёслолын ажиллагааг эхлүүлнэ.

3.5. Шүүгч тангараг өргөхдөө шүүгчийн өмсгөлтэй байх бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль дээр баруун гараа тавьж, шүүгчийн тангаргийг дээдлэн дуудна. Шүүгчийн тангаргийг хамтаар өргөж байгаа тохиолдолд хамгийн ахмад шүүгч нь тангаргийг дээдлэн дуудаж, бусад нь дагалдана.

3.6. Тангараг өргөсний дараа төрийн сүлдэнд мэхийн ёсолж, зүүн өвдөг сөхрөн Монгол Улсын төрийн далбаанаас адис авч, “Шүүгчийн тангаргийн бичиг”-т гарын үсгээ зурна. Тангараг өргөсөн шүүгчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн хувийг шүүгчийн үнэмлэхийн хамт гардуулж өгнө.

3.7. “Шүүгчийн тангаргийн бичиг” нь 210/297 мм хэмжээтэй, цагаан дэвсгэртэй, дотор нүүрэн талдаа Монгол Улсын төрийн сүлдтэй, түүний дор “Монгол Улсын шүүгчийн тангаргийн бүрэн бичвэртэй”, шүүгчийн овог, нэр, тангараг өргөсөн он, сар, өдөр, газрыг бичиж гарын үсэг зурах хэсэгтэй байна. Тангаргийн бичгийн гадна нүүрэн талд шүүхийн “дэнс”-ийг дүрсэлсэн, түүний дор монгол бичгээр “Монгол Улсын шүүгчийн тангаргийн бичиг” гэсэн бичвэртэй байх бөгөөд дотор болон гадна нүүрэн тал шаргал өнгийн түмэн наст хээ хүрээтэй байна.

3.8. Шүүгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан тангараг өргөсөн шүүгчид баяр хүргэж, Монгол Улсын Төрийн дуулал эгшиглүүлснээр ёслолын ажиллагаа дуусгавар болно.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Шүүгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаанд төр, захиргааны байгууллагын төлөөлөгчид, түүнчлэн олон нийтийн болон хэвлэл, мэдээллийн байгууллага, иргэдийн төлөөлөгчдийг урилгаар оролцуулж болно.

4.2. Тангараг өргөх ёслолын ажиллагааг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл ашиглан баримтжуулж болно.

4.3. Тангараг өргөх ёслолын ажиллагааны талаар тэмдэглэл хөтөлж, тангаргийн хуудасны хамт шүүгчийн хувийн хэрэгт хадгална.


Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны
12 дугаар сарын 07-ны өдрийн 12 дугаар
тогтоолын хавсралт

Хууль
Амгалан
Салбар
УХА0052 1701517



ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ
ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠰᠡᠭᠡᠨ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны
10 дугаар сарын 01 ны өдрийн 34 дугаар
тогтоолын хавсралт



ᠰᠢᠭᠦᠭᠴᠢᠶᠢᠨ



ᠲᠠᠩᠭᠠᠷᠠᠭ

ШҮҮГЧИЙН ТАНГАРАГ

Шүүгч би шүүх эрх мэдлийн ариун журамт үүрэг, Монгол Улсын Үндсэн хуульт байгуулал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж, хэрэг, маргааныг хэнээс ч хараат бус, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйг чанд сахиж явахаа ард түмэндээ батлан тангараглая.

Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал шүүгчийн албан тушаалаас нэн даруй огцорч, хуульд заасан хариуцлага хүлээнэ.


(Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг)

ТАНГАРАГ ӨРГӨСӨН:

..... шүүхийн шүүгч
Ургийн овог:
Эцэг /эх/-ийн нэр:
Нэр:
Гарын үсэг:
Тангараг өргөсөн газар:

... он ... сар ... өдөр

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны
10 дугаар сарын 04 ны өдрийн 34 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт



ШҮҮГЧИЙН ӨМСГӨЛИЙН ЗАГВАР, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын шүүхийн шүүгчийн өмсгөлийн загвар, хэрэглэх, шүүгчид олгох, хадгалуулах, буцааж авах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Хоёр. Шүүгчийн өмсгөлийн загвар

2.1. Монгол Улсын шүүхийн шүүгчийн өмсгөл /цаашид "Шүүгчийн өмсгөл" гэх/ нь шүүгчийн хараат бус байдлын бэлгэдэл, шүүхийн нэр төр, шүүгчийн албан тушаалын алдар хүндийн илэрхийлэл мөн.

2.2. Шүүгчийн өмсгөл нь шүүгчийн ажлын онцлогийг харгалзсан, дэлхийн улс орны шүүхийн шүүгчийн албаны өмсгөлийн нийтлэг жишигт үндэслэсэн, Монгол үндэсний хувцасны хэв шинжийг тусгасан, чанартай материалаар хийгдсэн, хар өнгөтэй байна.

2.3. Шүүгчийн өмсгөл нь сул чөлөөтэй хэлбэртэй, босоо захтай, энгэр нь уулзсан зөрлөгтэй, зангидмал таван товчтой, дотортой байна.

2.4. Мөрний оёдлын энгэр талд нугалаас гаргаж, өмсгөлийг өргөн чөлөөтэй болгоно.

2.5. Шүүгчийн өмсгөлийн зах, бартааны ирмэгүүдийг 5 см өргөнтэй, хар өнгийн торгомсог даавуугаар эмжинэ.

2.6. Шүүгчийн өмсгөлийн энгэрийн товч, шилбийг хар өнгийн торгомсог даавуугаар хийнэ.

2.7. Шүүгчийн өмсгөлийн ханцуй нь үзүүр рүүгээ өргөн хэлбэртэй, нударга маяг гарган залгасан хэсэгт 0,1 см өргөнтэй хавчуургатай байна.

2.8. Шүүгчийн өмсгөл нь хэмжээтэй байх бөгөөд урт нь хөлийн шагайнаас илүүгүй байна.

Гурав. Шүүгчийн өмсгөлийг хэрэглэх журам

3.1. Шүүгчийн өмсгөлийг зөвхөн тангараг өргөх ёслолын ажиллагааны болон шүүх хуралдааны үед өмсөнө.

3.2. Өмсгөл дээр шүүгчийн энгэрийн тэмдэг зүүж болох бөгөөд тэмдэг нь албан ёсоор батлагдсан загварын дагуу байна.

3.3. Шүүгч өмсгөлдөө гүн хүндэтгэлтэй хандаж, цэвэр үзэмжтэй байлгана.

3.4. Шүүгчийг томилогдсоноос хойш 30 хоногийн дотор түүнд шүүгчийн өмсгөлийг шүүхийн тамгын газраас олгох бөгөөд шүүгч албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, огцорсон тохиолдолд буцааж авна.

3.5. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон шүүгчид шүүхийн тамгын газраас шүүгчийн өмсгөлийг хадгалуулж болно.

3.6. Өмсгөлийн эдэлгээний хугацаа таван жил байх бөгөөд хугацаа нь дуусаагүй шүүгчийн өмсгөлийг үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд түүний эдэлгээний элэгдлийг хассан үнийг буруутай этгээдээр төлүүлнэ.

3.7. Эдэлгээний хугацаа дууссан шүүгчийн өмсгөлийг шинэчлэн олгохтой холбоотой ажлыг тухайн шүүхийн тамгын газар хариуцан зохион байгуулна.

3.8. Шүүгч нь нөөц өмсгөлтэй байж болох бөгөөд нөөц өмсгөл нь Монгол орны уур амьсгалын аль бүст хамаарч байгаагаас шалтгаалан нимгэн, зузаан гэсэн хоёр төрөлтэй байна.

3.9. Шүүгчид анх олгох өмсгөлийн зардлыг шүүхийн төсөвт жил бүр тусгуулах ба харин нөөц өмсгөлийн зардлыг шүүгч өөрөө хариуцна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны
10 дугаар сарын 01-ны өдрийн 39 дугаар
тогтоолын хавсралт



Шүүгчийн өмсгөлийн загвар

5 см өргөн зах баргааны ирмэг

Хар өнгийн 5 ширхэг товч, шилбэ



0,1 см өргөнтэй хавчуурга